



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/519

Чингис хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Согтууруулах, ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны эдрийн А/515 дугаар захирамжийн 2 дахь заалтыг зөрчиж, согтууруулах ундаа худалдсан Хэрлэн сумын "Далайхан" ХХК-ний хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/-д даалгасугай.

3. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010963